

Ядуурлын Үнэлгээний Хуудас

Монгол улс

Simple Poverty Scorecard® Poverty-Assessment Tool

Марк Шрайнэр
2016.04.04

This document is in English at SimplePovertyScorecard.com

Энэхүү баримт бичиг болон дагалдах барим бичгийн хамт

SimplePovertyScorecard.com вэб сайтанд дээр монгол хэл дээр байрласан байна.

Хураангуй

Энэхүү Ядуурлын Үнэлгээний Хуудас нь Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны 2014 Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Судалгааны мэдээлэл дээр үндэслэсэн зардал багатай, ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрхөд тооцогдож болзошгүй өрхүүдийн магадлалыг тооцоолох 12 асуултаас бүрдсэн асуулга юм. Ядуурлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аль ч байгууллагын салбарын ажилтан энэхүү судалгааг ойролцоогоор 10 минутанд авах боломжтой. Уг үнэлгээний хуудасны нарийвчлалыг ядуурлын бүх түвшний шугамыг ашигласнаар гаргах боломжтой юм. Ядуурлын Үнэлгээний Хуудсыг Монгол дахь ядуурлыг бууруулах зорилгоор хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд ядуурлын түвшинг хэмжих, тодорхой цаг хугацааны дараа ядуурлын түвшиний өөрчлөлтийг хянах болон зорилтот үйлчилгээ/бүтээгдэхүүнд хамруулах харилцагчдыг хэсэгчилэн ангилах зэрэг боломжийг олгодог шалгарсан практикийн аргачлал юм.

Талархал

Энэхүү баримт бичиг нь Дэлхийн Зөн Монгол ОУБ, ВишнФанд ББСБ, Улсын Бүртгэл, Статистикийн Ерөнхий Газар (УБСЕГ), Монгол Улсын Сангийн Яам, Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан болон Хас Банкнаас үзүүлсэн санхүүгийн болон бусад төрлийн дэмжлэгээр Грамийн Фаундэйшн (АНУ дахь Ашгийн бус Байгууллага)-аар санхүүжилтээр боловсруулагдсан юм. УБСЕГ-аас дата мэдээллээр хангаж хамтран ажилласан Савөнг Чанн, Д. Оюунчимэг, Винсент Эдвардс, Э. Уянга, Э. Мягмарханд, Жон Хийбэрт, Л. Мягмарсүрэн, М. Оюунцэцэг, Х. Нямхүү, Жулие Пийчей, Шарада Раманатан, С. Болормаа, С. Лхагвасүрэн, С. Агьзул, Ц. Сүнжидмаа болон Т. Баярмаа нарт гүн талархал илэрхийлье. Энэхүү Үнэлгээний Хуудас нь мөн PPI - Progress out of Poverty Index® буюу Ядуурлаас Гарах Өөрчлөлтийн Индекс хэмээн танигдсан юм. Грамийн Фаундэйшн нь өөрсдийн харилцагч нарын ядуурлыг хэмжих болоод нийгмийн эрхэм зорилгодоо илүү үр дүнтэйгээр хүрэх зорилготой байгууллагуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор энэхүү PPI® аргачлалыг удирдан хэрэгжүүлдэг юм. PPI® аргачлалтай холбоотой материал болон эх сурвалжууд progressoutofpoverty.org вэб сайтанд дээр байрласан байна. “Simple Poverty Scorecard” is a Registered Trademark of Microfinance Risk Management, L.L.C. for its brand of poverty-assessment tools.

Ядуурлын Үнэлгээний Хуудас

Ярилцлагын дугаар: _____	<u>Нэр</u>	<u>Тусгай дугаар</u>
Ярилцлага хийсэн он сар өдөр: _____	Асуугдагч: _____	_____
Улс: <u>MNG</u>	Салбарын судлаач: _____	_____
Үнэлгээний хуудас: <u>001</u>	Судалгаа явагдсан газар: _____	_____
Түүврийн жин: _____	Өрхийн ам бүлийн гишүүдийн тоо: _____	_____

Асуулт	Хариулт	Оноо	Дүн
1. Өрхийн ам бүл хэдэн гишүүнтэй вэ?	A. Зургаа болон түүнээс дээш B. Тав C. Дөрөв D. Гурав E. Хоёр F. Нэг	0 4 8 15 25 30	
2. Эрэгтэй өрхийн тэргүүний суралцаж дүүргэсэн боловсролын дээд түвшин юу вэ?	A. Боловсролгүй, бага, эсвэл суурь эсвэл бүрэн дунд B. Эрэгтэй өрхийн тэргүүн байхгүй C. Техникийн болон мэргэжлийн D. Тусгай мэргэжлийн дунд E. Дипломын дээд, бакалавр болон түүнээс дээш	0 0 3 4 7	
3. Танай өрхийн одоогийн амьдарч буй сууцны төрөл юу вэ?	A. Гэр B. Хашаа байшин, оюутан сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байр, зориулалтын бус сууц болон бусад сууц C. Орон сууцны байшин эсвэл тансаг зэрэглэлийн байшин	0 0 100	
4. Хэрвээ сууц нь гэр биш бол, сууцны ханын үндсэн материалын төрөл юу вэ?	A. Гэр B. Мод, чулуу, бусад C. Тоосго юм уу бетон	0 6 10	
5. Хэрэв сууц нь гэр бол, гэр нь хэдэн ханатай гэр вэ?	A. Гэр биш B. Гурав эсвэл дөрөв C. Тав D. Зургаа эсвэл түүнээс дээш	0 0 5 9	
6. Танай өрх одоогийн байдлаар хэдэн толгой үхэртэй вэ?	A. Тэгээс дөрөв хүртэл (0–4) B. Таваас ес хүртэл (5–9) C. Арваас хорин ес хүртэл (10–29) D. Гуч эсвэл түүнээс дээш (≥30)	0 4 8 13	
7. Танай өрхөд ажиллаж байгаа угаалгын машин бий юу?	A. Үгүй B. Тийм	0 2	
8. Танай өрхөд ажиллаж байгаа зуух/пийшин, цахилгаан/хийн зуух эсвэл шарах шүүгээ бий юу?	A. Байхгүй B. Зуух/пийшин бий, бусад нь байхгүй C. Цахилгаан/хийн зуух бий, шарах шүүгээ байхгүй (зуух/пийшин байгаа эсэх нь хамаагүй) D. Шарах шүүгээ бий (бусад нь байгаа эсэх нь хамаагүй)	0 3 4 8	
9. Танай өрхөд ажиллаж байгаа битүү чанагч/будaa агшаагч бий юу?	A. Үгүй B. Тийм	0 3	
10. Танай өрхөд ажиллаж байгаа цахилгаан индүү бий юу?	A. Үгүй B. Тийм	0 2	
11. Танай өрхөд ажиллаж байгаа тоос сорогч бий юу?	A. Үгүй B. Тийм	0 4	
12. Танай өрхөд ажиллаж байгаа мотоцикл эсвэл автомашины (суудлын автомашин, ачааны болон хүнд даацын машин, автобус) аль нэг нь бий юу?	A. Байхгүй B. Зөвхөн мотоцикл бий C. Автомашин бий /мотоцикл байгаа эсэх нь хамаагүй /	0 5 11	

Ажлын тэмдэглэл: Өрхийн гишүүд

Үнэлгээний хуудасны тэргүүн хэсэгт ярилцлагын тусгай дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/, ярилцлагын он сар өдөр, түүврийн жин /мэдэгдэж байгаа бол/ бичнэ. Дараа нь судалгаанд оролцогчийн нэр болон судалгаа авсан хүн өөрийнхөө нэр, тусгай дугаарыг бөглөж, судалгаа хийгдсэн газрын нэрийг бичнэ. Судалгаанд оролцогч нь асуугдагч байх шаардлагагүй.

Судалгаанд оролцогчоос: Өрхийн гишүүн бүрийг өрхийн тэргүүнээс эхлэн нэрээ хэлэхийг асууна уу. Өрх гэдэг нь нэг болон түүнээс дээш тооны хамтын төсөвтэй, хамтран амьдарч, хооллож байгаа хүмүүсийг хэлэх бөгөөд тэдгээр нь цусан төрлийн холбоогүй гэрлээгүй хүмүүс байж болно.

Асуултанд хариулах өрхийн гишүүн мөн эсэх. Асуулгын 2 дугаар хуудаст заасны дагуу: Сүүлийн 12 сарын хугацаанд хамгийн багадаа 6 сар тухайн өрхөд (гол төлөв хамтын төсөвтэй, хамтран амьдарч, хооллож байгаа) гэсэн дээрх гурван шалгуурыг хангасан хүнийг Өрхийн гишүүнд тооцно.

Өрхийн тэргүүн болон оюутан, сурагчдын хувьд өнгөрсөн бүтэн 12 сарын хугацаанд дээрх гурван шалгууруудыг хангасан тохиолдолд Өрхийн гишүүнд тооцно.

Өрхийн гишүүдийн тоог гаргаад тэргүүн хэсэгт “Өрхийн гишүүдийн тоо” гэсэн хэсэгт бөглөнө. Мөн үнэлгээний хуудсан дахь эхний үзүүлэлтэнд тохирох хариултыг дугуйлна.

“Үзүүлэлтийг хөрвүүлэх заавар” дахь өрх болон өрхийн гишүүдийн тухай бүрэн тодорхойлолтыг байнга санаж байх хэрэгтэй.

Нэрс
1.
2.
3.
4.
5.
6.
7.
8.
9.
10.
11.
12.
13.
14.
15.
Өрхийн нийт гишүүд:

Үнэлгээний дүнг ядуурлын магадлал руу шилжүүлэх хүснэгт

Score	<u>Үндэсний Ядуурлын Шугамууд</u>			Хамгийн ядуу хагас <100% үндэсний хэмжээнд	<u>2005 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам</u>				<u>2011 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам</u>				<u>Хувьчилсан ядуурлын шугамууд</u>				
	100%	150%	200%		\$1.25	\$2.00	\$2.50	\$5.00	\$1.90	\$3.10	\$3.80	\$4.00	20 th	40 th	50 th	60 th	80 th
0-4	100.0	100.0	100.0	89.4	8.8	58.2	83.2	100.0	8.8	56.8	82.9	83.2	100.0	100.0	100.0	100.0	100.0
5-9	93.3	99.3	100.0	77.4	8.5	58.2	67.0	98.2	7.5	55.8	65.0	67.0	93.3	96.4	99.3	100.0	100.0
10-14	80.0	96.7	99.6	61.9	1.1	24.2	46.7	93.6	1.1	21.4	41.5	46.7	78.1	91.9	96.9	98.8	99.7
15-19	67.6	92.1	97.4	42.6	1.0	12.4	31.3	89.3	0.9	10.5	26.5	31.3	63.4	87.9	92.6	95.0	98.4
20-24	50.6	85.8	94.6	23.6	0.4	5.5	13.4	79.3	0.1	3.4	11.2	13.4	47.0	76.9	85.9	89.9	97.8
25-29	35.0	74.7	92.4	12.9	0.1	1.8	6.6	67.9	0.1	1.6	4.1	6.6	31.7	63.7	75.7	86.2	96.6
30-34	17.1	60.4	84.5	4.6	0.1	0.8	2.7	51.7	0.1	0.7	1.7	2.7	14.6	48.2	62.1	74.3	93.5
35-39	9.7	48.1	76.3	2.6	0.0	0.3	1.5	39.3	0.0	0.3	0.9	1.5	8.5	33.9	49.5	63.4	87.3
40-44	4.5	32.5	65.7	1.1	0.0	0.0	0.7	23.1	0.0	0.0	0.5	0.7	3.9	19.1	33.7	49.7	82.4
45-49	2.3	23.5	50.8	0.2	0.0	0.0	0.1	14.1	0.0	0.0	0.1	0.1	2.0	12.2	24.2	36.1	68.3
50-54	1.2	11.4	34.6	0.2	0.0	0.0	0.1	7.6	0.0	0.0	0.1	0.1	1.2	5.9	11.8	20.8	54.4
55-59	0.9	9.3	25.8	0.2	0.0	0.0	0.1	6.7	0.0	0.0	0.1	0.1	0.9	5.9	9.4	17.4	47.7
60-64	0.9	9.3	25.8	0.2	0.0	0.0	0.1	6.7	0.0	0.0	0.1	0.1	0.9	5.9	9.4	17.4	40.4
65-69	0.9	9.3	25.8	0.2	0.0	0.0	0.1	6.7	0.0	0.0	0.1	0.1	0.9	5.9	9.4	17.4	40.4
70-74	0.9	9.3	25.8	0.2	0.0	0.0	0.1	6.7	0.0	0.0	0.1	0.1	0.9	5.9	9.4	17.4	40.4
75-79	0.9	9.3	25.8	0.2	0.0	0.0	0.1	6.7	0.0	0.0	0.1	0.1	0.9	5.9	9.4	17.4	40.4
80-84	0.9	9.3	25.8	0.2	0.0	0.0	0.1	6.7	0.0	0.0	0.1	0.1	0.9	5.9	9.4	17.4	40.4
85-89	0.9	9.3	25.8	0.2	0.0	0.0	0.1	6.7	0.0	0.0	0.1	0.1	0.9	5.9	9.4	17.4	40.4
90-94	0.9	9.3	25.8	0.2	0.0	0.0	0.1	6.7	0.0	0.0	0.1	0.1	0.9	5.9	9.4	17.4	40.4
95-100	0.9	9.3	25.8	0.2	0.0	0.0	0.1	6.7	0.0	0.0	0.1	0.1	0.9	5.9	9.4	17.4	40.4

Үнэлгээний хуудсын үзүүлэлтийг хөрвүүлэх зааварчилгаа

Доорх ишлэлийг авсан материал:

УБСЕГ, 2013 “Судлаачийн гарын авлага: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” 2014, (Гарын авлага), Улаанбаатар болон

УБСЕГ, 2013 Асуулгын маягт: “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” 2014, Улаанбаатар

Судлаач нь зөвхөн “Зааварчилгаа”-нд заагдсан дүрмийн дагуу ажиллана

Хэрэв энд тусгагдаагүй асуудал гарвал Үндэсний Статистикийн Хороо (УБСЕГ) 2014 оны Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Судалгаа /ӨНЭЗС/-г явуулсны адил судлаач нь өөрийн шүүмжин дээр үндэслэн шийдвэрийг гаргана. Ядуурлын үнэлгээний хуудсыг ашиглаж буй аль ч байгууллага нь тухайн байгууллагын салбарууд дээр хэрэглэгдэх ямар нэгэн өөр тодорхойлолт, дүрэм журмыг /”Зааварчилгаанд” заагдсанаас бусад/ тарааж мэдээллэх ёсгүй. Энэхүү Зааварчилгаанд заагдсанаас бусад тодорхойгүй асуудлыг тухайн судлаачийн өөрийн шүүмж дээр үндэслэн шийдэх асуудал хэмээн үлдээнэ. Энэ нь УБСЕГ-ны 2014 оны ӨНЭЗС-ы туршлагыг дагана гэсэн үг юм.

Үнэлгээний хуудсын асуултыг асуух ерөнхий зааварчилгаа

Үнэлгээний хуудсын тэргүүн хэсэг болон “Ажлын тэмдэглэл”-ийн хуудсыг Ажлын тэмдэглэл дэх зааврын дагуу хамгийн эхэнд бөглөнө.

Үнэлгээний хуудасны асуултыг (“Танай өрхийн ам бүл хэд вэ?”) шууд битгий асуу. Харин оронд нь “Ажлын тэмдэглэл” хуудсанд бөглөсөн мэдээллийн дагуу хариултыг тодорхойлж дугуйлна уу. Мөн та үнэлгээний хуудасны тэргүүн хэсэгт байрлах “Өрхийн ам бүлийн гишүүдийн тоо:” гэсэн хэсэгт өрхийг ам бүлийн гишүүдийн тоог бүртгэнэ.

Асуултыг үнэлгээний хуудсан дээр бичигдсэн дарааллын дагуу үгчлэн уншиж асууна уу.

Үнэлгээний хуудсан дахь тохирох хариултыг тэмдэглэхдээ хариултын хувилбарыг онооны хамт нийтэд нь доорх байдлаар дугуйлж, оноог “дүн”-ийн баганад хуулж тавина.

3. Танай өрхийн одоогийн амьдарч буй сууцны төрөл юу вэ?	А. Гэр	0	
	В. Хашаа байшин, оюутан сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байр, зориулалтын бус сууц болон бусад сууц	0	0
	С. Орон сууцны байшин эсвэл тансаг зэрэглэлийн байшин	100	

Ядуурлыг үнэлэх хуудас, Ажлын тэмдэглэл болон энэхүү “Зааварчилгаа” нь монгол хэл дээр орчуулагдсан болно. Үнэлгээний хуудас нь давхар англи хэл бичигдсэний зэрэгцээ үнэлгээ нь өөрөө асуугдаж буй өрхийн хэл дээр явагдах ёстой (гол төлөв монгол хэл дээр). Монгол, англи хэл дээрх хувилбарууд нь хоорондоо нийцэхгүй тохиолдолд монгол хувилбарыг дагана. Тухайлбал, үнэлгээний хуудасны асуултууд болон хариултын хувилбаруудыг үнэлгээний хуудасны монгол хэл дээрх текстээс шууд авч хэрэглэнэ. Энэхүү “Зааварчилгаа” нь монгол хэл дээрх ӨНЭЗС-ийн судлаачийн гарын авлагын үндсэн эх дээр суурилсан болно.

Ихэнх тохиолдолд, хариултын хувилбаруудыг асуугдагчид битгий уншиж өг. Зөвхөн асуултыг унш, тэгээд азна, хариултыг хүлээ. Хэрэв асуугдагч нь тодруулага хүсэх эсвэл хариулахаас төвөгшөөх, эргэлзэж байвал, асуултыг уншиж өг, эсвэл та өөрөө судлаачийн хувьд тохиромжтой гэж үзэж байвал “Зааварчилгаа”-нд заагдсан нэмэлт зааврыг ашигла .

Ихэнх тохиолдолд та асуугдагчийн өгсөн хариултыг л бүртгэх ёстой. Гэвч асуугдагчийн өгсөн хариулт нь танд үнэн зөв биш, тодорхойгүй эсвэл асуугдагч нь хэрхэн хариулах тал дээр тусламж авах хүсэлтэй байвал, та асуултаа дахин нэг тавьж “Зааварчилгаа”-нд заагдсан тохирох зааврыг ашиглах хэрэгтэй.

Ядуурлын үнэлгээний хуудсан дахь асуултууд нь шалгарсан асуултууд учир хариултуудыг ихэнхдээ нягтлан шалгах шаардлагагүй. Хариулт нь үнэн зөв эсэхэд та эргэлзэж байвал эсвэл ийнхүү нягтлах нь мэдээллийн чанарыг сайжруулах нөлөөтэй гэж үзэж байгаа тохиолдолд л та хариултыг нягтлан шалгаж болно.

Жишээ нь: Асуугдагч нь эргэлзэж, сандарч эсвэл худал мэдээлэл өгч, будилж байгаа зэрэг шинж тэмдгүүд илэрсэн тохиолдолд та нягтлан шалгаж болох юм. Мөн хөрш юм уу өрхөд багтах хүүхдийн хэлсэн зүйл асуугдагчийн хариултаас зөрсөн бол нягтлан шалгах нь зүйтэй.

Тухайн өрхийн эзэмшилд удаан эдэлгээтэй бараа байхгүй болох нь баталгаажих эсвэл хүүхэд өрхийн гишүүнд бүртгэгдээгүй хэрнээ өрөөн дотор хооллож байх зэрэг нь хариултыг үнэн зөв эсэхэд эргэлзээ төрүүлж байвал нягтлан шалгах нь зүйтэй юм.

Ихэнхдээ үнэлгээний хуудсын ашиглалт нь УБСЕГ-ны 2014 оны ӨНЭЗС-ны ашиглалтын дагуу аль болох адилхан явагдах ёстой. Тухайлбал, ядуурлын үнэлгээний хуудсыг асуух

ярилцлага нь асуугдагчийн оршин сууж буй газар явагдах ёстой, учир нь 2014 оны ӨНЭЗС нь мөн адил ийнхүү явагдсан юм.

Өрхийн өгсөн мэдээлэл нь нууцлалын зэрэгтэй байна. Тухайн мэдээллийг ашиглах шаардлагатай байгууллагын дотоод ажилтнуудаас бусад гадны аль ч этгээдэд мэдээллийг дамжуулж, задруулж болохгүй.

Асуугдагч нь хэн байх ёстой вэ?

УБСЕГ-ны дагуу, асуугдагч нь өрхийн тэргүүн байх хэрэгтэй. Хэрэв өрхийн тэргүүн нь боломжгүй бол, тухайн өрхийг бүрэн төлөөлөн асуултанд хариулах чадвартай өрхийн гишүүн байна. Асуугдагч нь тухайн байгууллагын харилцагч болох өрхийн гишүүн өөрөө байх шаардлагагүй юм.

Биедээ юу авч явах вэ?

“Зааварчилгааг” өөрийн болтол судлаад бүх судалгааны турш биедээ авч явах хэрэгтэй.

Асуугдагчаас ярилцлага авах:

Судлаачийн гарын авлагын дагуу эхлээд та асуугдагчтай сайн харилцаа тогтгоох хэрэгтэй юм. Та өрхийн гишүүдтэй эелдэг хүндэтгэлтэй харьцаж ярилцлага эхэлхээс өмнө найрсагаар мэндчилэн, өөрийгөө болон судалгааны ажлын зорилгыг (өөрийн байгууллагын харилцагчдын амьдралыг илүү судлан таних) танилцуулан мэдээллийн нууцлалыг чандлан хадгална гэдгийг хэлнэ. Мөн судалгаа нь 10-15 минут үргэлжилнэ гэдгийг асуугдагчид хэлнэ.

Үргэлж эерэг хандлагыг хадгалж эрч хүчтэй бай.

Асуугдагчаас ярилцлагыг гурав дагч этгээд буюу өрхийн гишүүн бус хүмүүст сонсогдохгүй байхаар авна уу. Ярилцлагын үеэр өрхийн бус гишүүн дэргэд байх нь асуугдагчийг үнэн бус мэдээлэл өгөхөд нөлөөлж болзошгүй юм.

Үргэлж төвийг сахь. Асуугдагчдад үг, биеийн хэл, дуу хоолойны өнгө зэргээр асуултанд “буруу” эсвэл “зөв” хариулт өгсөн гэдгийг мэдээллэх дохионуудыг бүү өгөөрэй.

Асуултыг асуух үедээ үнэлгээний хуудасны дарааллаар уншина уу. Асуулт бүрийг үг бүрчлэн бүхэлд нь уншиж асууна. Асуултын дараалал болон үгчилсэн байдлыг өөрчлөх хэрэггүй.

Хэрэв асуугдагч нь олон талтай, тодорхойгүй эсвэл хамааралгүй хариулт өгвөл төвийг сахисан байдлаар тодруулахыг хичээ. Асуугдагчдад хэзээ ч хариултыг санал болгож болохгүй. Харин асуугдагчдад үнэн зөв хариултыг өөрөө өгөхөд нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Хэрэв асуугдагч нь асуултыг ойлгоогүй бол, асуултыг удаан болон тодоор давтаж асууна. Хэрэв асуугдагч нь үүний дараа ч мөн адил ойлгохгүй байвал та асуултыг өөр үгээр, ямар нэгэн нэмэлт санааг оруулахгүйгээр үндсэн санааг ойлгуулж дахин асууна.

Ярилцлагын туршид итгэлцлийн уур амьсгалыг бүрдүүлж ажиллана. Судлаач нь асуугдагчийг айлган сүрдүүлэх бус харилцагчтай найрсаг, сайн ойлголцож, хариу үзүүлэн ажиллах нь ярилцлагын хамгийн зүйтэй нөхцөл байдал юм.

Асуугдагчаас хариулт өгөхийг хүчлэн шаардаж болохгүйг санаарай. Хэрэв асуугдагчийн хувьд ярилцлага өгөх цаг нь тохиромжгүй учир асуултанд хайхрамжгүй хариулж, яаруу сандруу байвал өөр тохиромжтой үед эргэн ирж ярилцлагын цагийг товлох боломжтой.

Асуугдагчтай үргэлж соёлтой харьцаж ширүүн, ёс зүйгүй заналхийлсэн хандлагыг бүү харуул.

Мэдээллийг бүү гуйвуул. Зөвхөн асуугдагчийн өгсөн хариулыг бүртгэнэ.

Үнэлгээний хуудасны зарим асуултуудын зааварчилгаа

1. Өрхийн ам бүл хэдэн гишүүнтэй вэ?

- A. Зургаа болон түүнээс дээш
- B. Тав
- C. Дөрөв
- D. Гурав
- E. Хоёр
- F. Нэг

Өрхийн ам бүл хэдэн гишүүнтэй вэ? гэсэн асуултыг асуугдагчаас шууд битгий асуу. Харин оронд нь “Ажлын тэмдэглэл” дэх өрхийн гишүүдийн тухай цуглуулсан мэдээлэл дээрээ үндэслэн хариултыг дугуйл.

“ӨНЭЗС”-д заасны дагуу “Өрх гэдэг нь хамтын төсөвтэй, хамтран амьдарч, хооллож байгаа нэг болон нэг хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хоорондоо төрөл садан ба төрөл садан биш ч байж болно”.

Асуулгын 2 дугаар хуудаст заасны дагуу: Сүүлийн 12 сарын хугацаанд нийтдээ хамгийн багадаа 6 сар тухайн өрхөд (гол төлөв хамтын төсөвтэй, хамтран амьдарч, хооллож байгаа) гэсэн дээрх 3 шалгуурыг хангасан хүнийг Өрхийн гишүүнд багтаана.

Өрхийн тэргүүн болон оюутан, сурагчдын хувьд өнгөрсөн 12 сарын хугацаанд дээрх 3 шалгуураас ядаж нэгийг хангасан байх ёстой.

“ӨНЭЗС”-д заасны дагуу “Өрх гэдэг нь гэр бүл гэсэн ойлголтоос ялгаатай юм. Гэр бүл гэдэг нь нийгмийн харилцаа, цусан төрлийн холбоо, гэрлэлтээр хоорондоо холбогдсон хүмүүст хамаарна. Харин өрх гэдэг нь эдийн засгийн хувьд бие даасан нэгжийн тухай ойлголт юм. Хэдийгээр гэр бүл, айл өрх гэдэг ихэвчлэн адилхан мэт ойлголт боловч тэр болгон нэг утгаар энэ ойлголтыг хэрэглэж болдоггүй.”

Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүнийг тодорхойлох энэхүү нарийн төвөгтэй асуудалд судлаач та бүхэн маш болгоомжтой хянуур хандах ёстой. Жишээ нь:

- Гэрийн үйлчлэгч, бусад хөлсөөр ажилладаг хүмүүс нь тусдаа өрхийн тэргүүн бүхий өрхөд хамаардаг
- Тухайн өрхийн байранд хөлсөөр суудаг хүмүүс байвал өрхийн гишүүнд тооцогдохгүй, учир нь өрхийн байранд болон хүнсэнд мөнгө төлөх нь өрхийн нэгдсэн төсвийг бүрдүүлэхтэй адилгүй юм

УБСЕГ-ны зааварчилгааны дагуу, өрхийн шинэ гишүүн (шинээр төрсөн хүүхэд ба шинэ нөхөр/эхнэр гэх мэт) тухайн өрхөд хамгийн багадаа 6 сар амьдраагүй бол өрхийн гишүүнд тооцохгүй ба асуулгад хамруулахгүй. Учир нь ӨНЭЗС-ны зорилго нь өрхийн сүүлийн 12 сарын орлого, зарлагыг тооцох үндсэн зорилготой ба шинэ гишүүдийн хувьд 12 сарын хагасаас илүү хугацаанд дээрх тооцоонд оролцоогүй байдаг.

Энэ утгаараа тухайн өрхөд 6 болоон түүнээс дээш сар амьдарсан хүн бүрийг өрхийн гишүүнд багтаан тоолох ба судалгаа явуулах үед аль нэг гишүүн байхгүй /жишээ нь явчихсан, нас барсны улмаас/ байсан ч хамруулж тооцно.

2. Эрэгтэй өрхийн тэргүүний суралцаж дүүргэсэн боловсролын дээд түвшин юу вэ?
- A. Боловсролгүй, бага, эсвэл суурь эсвэл бүрэн дунд
 - B. Эрэгтэй өрхийн тэргүүн байхгүй
 - C. Техникийн болон мэргэжлийн
 - D. Тусгай мэргэжлийн дунд
 - E. Дипломын дээд, бакалавр болон түүнээс дээш

УБСЕГ-ны зааварчилгааны дагуу “тухайн хүний эзэмшсэн боловсролын хамгийн дээд түвшинг тэмдэглэнэ”. Жишээ нь: судалгаанд оролцогч нь тусгай мэргэжлийн дундыг дүүргэсэн хэрнээ зэрэгт хөтөлбөрийг бүрэн дүүргэлгүйгээр зөвхөн эхний жилдээ суралцаж төгссөн бол (E. Дипломын дээд, бакалавр болон түүнээс дээш) гэсэн хувилбарыг бус харин (D. хувилбар болох Тусгай мэргэжлийн дунд) гэсэн хариултыг дугуйлна.

Хариултуудын сонголтонд жагсаасан академик түвшинд хамаарахгүй курс болон дамжааг оруулахгүй. Тухайлбал, тракторын жолооч, гоо сайхны юмуу хэлний курс гэх мэт ямар ч төрлийн дамжаа нь тухайн хүний эзэмшсэн боловсролын түвшинг тодорхойлохгүй. Хэрэв өрхийн эрэгтэй тэргүүн бүрэн дунд сургуулийг дүүргээгүй боловч гагнуурчны дамжааг дүүргэсэн хэдий ч мэргэжлийн гэрчилгээ аваагүй байсан ч (A. Боловсролгүй, бага, эсвэл суурь эсвэл бүрэн дунд) гэсэн хариултыг дугуйлна.

Судлаачийн гарын авлагын дагуу бүрэн дунд боловсролыг дүүргэсэн гэдэг нь өрхийн эрэгтэй тэргүүн дараах ангиудыг дүүргэсэн болно:

- 10 дугаар анги (2005 ба түүнээс өмнөх онуудад)
- 11 дүгээр анги (2006–2007 онуудад)
- 12 дугаар анги (2008 ба түүнээс хойшхи онуудад)

Судалгаачийн гарын авлагын дагуу, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв(хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС)-ийг төгссөн мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг “Техникийн болон мэргэжлийн” боловсролтой гэж ойлгоно. Гадаад/дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг “Тусгай мэргэжлийн дунд” боловсролтой гэж үзнэ.

Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн, Улсын Багшийн Их Сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын Дээд Сургуулийг 1966 оноос өмнө, Намын Дээд Сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг “Дипломын дээд” боловсролтой гэж үзнэ E. Дипломын дээд, бакалавр болон түүнээс дээш гэсэн хариултыг дугуйлна.

Судлаачийн гарын авлагын 13-р хуудсын дагуу, Өрхийн тэргүүн гэдэг нь өөрийгөө өрхийн тэргүүн хэмээн үзэж байгаа хүнийг хэлнэ. Асуугдагч нь өөрийн үнэлэмжийн дагуу өрхийн тэргүүний шалгуурыг тодорхойлох боломжтой ба өрхийн тэргүүлэгч гэдэг нь гол төлөв бусдыг удирдан зохион байгуулах, өрхийн гол чухал асуудлуудыг шийдэхэд голлох үүргийг гүйцэтгэдэг, өрхийн талаарх асуудлыг бүрэн хариуцдаг, ихэнхи тохиолдолд өрхийн санхүүгийн асуудлыг шийдвэрлэдэг гишүүнийг хэлнэ.

Өрхийн тэргүүн гэж хамгийн багадаа сүүлийн 12 сард өрхөд байсан, насанд хүрсэн хүнийг хэлнэ. Хэрэв асуугдагч нь насанд хүрээгүй хүнийг өрхийн тэргүүнээр мэдээллэвэл, өрхөөс өөр насанд хүрсэн гишүүнийг өрхийн тэргүүнээр бүртгэнэ.

Үнэлгээний хуудасны зорилгын дагуу, **эрэгтэй өрхийн тэргүүнийг** дараах байдлаар тодорхойлно:

- Байгаад тооцно: Өрхийн тэргүүн, хэрэв тэргүүн нь эрэгтэй бол
- Байгаад тооцно: Хэрэв өрхийн тэргүүн нь эмэгтэй хэдий ч хамтран амьдрагчтай бол (албан бус болон албан ёсоор гэрлэсэн эсэх нь хамаагүй)
- Байхгүйд тооцно: хэрэв өрхийн тэргүүн нь эмэгтэй бөгөөд тухайн эмэгтэй нь энэхүү судалгааны өрхийн гишүүнд бүртгүүлсэн нөхөргүй буюу өрх толгойлсон эмэгтэй бол.

“Ажлын тэмдэглэл” дэх мэдээллийн хэсгийг бөглөж байхдаа хувьдаа тэмдэглэсэн зүйлээсээ өрхийн эрэгтэй тэргүүн/нөхрийн нэрийг тэмдэглэж авсанаа санаарай. Тиймээс хэрэв өрхөд эрэгтэй тэргүүн байвал “Эрэгтэй өрхийн тэргүүн/нөхрийн суралцаж дүүргэсэн боловсролын дээд түвшин юу вэ?” хэмээн үгчилж битгий асуугаарай. Үүний оронд, өрхийн тэргүүн/нөхрийн нэрийг дуудна, тухайлбал, “Чигисийн дүүргэсэн боловсролын дээд түвшин юу вэ?” Хэрэв өрхөд эрэгтэй тэргүүн/нөхөр байхгүй бол асуултыг огтхон ч унших шаардлага байхгүй ба В. Эрэгтэй өрхийн тэргүүн байхгүй гэсэн хариултыг дугуйлж дараагийн асуулт руу шилжинэ.

3. Танай өрхийн одоогийн амьдарч буй сууцны төрөл юу вэ?

- А. Гэр
- В. Хашаа байшин, оюутан сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байр, зориулалтын бус сууц болон бусад сууц
- С. Орон сууцны байшин эсвэл тансаг зэрэглэлийн байшин

Хэрэв өрх нь орон сууцны байшин болон тансаг зэрэглэлийн байшинд амьдардаг бол энэхүү асуултанд 100 оноог авна. Хамгийн дээд оноо нь 100 байх учир өрх нь бусад асуултанд хэрхэн хариулахаас үл хамааран орон сууцны байшин болон тансаг зэрэглэлийн байшинд амьдардаг бол 100 оноог авна.

Судлаачийн гарын авлагын дагуу, *сууц* гэдэг нь “өрх эсвэл хүн ам амьдарч байгаа бүх төрлийн орон байрыг хэлнэ. Үүнд: бүх төрлийн байшин, гэр, цаатны урц, оюутан, сурагчид, ажиллагчдын дотуур болон нийтийн байр, цэргийн хуаран, хорих ангийн байр, асрамжийн газрын байр, бусад төрлийн орон байрны хэсгийг (орцны хонгил дах байр, дулааны шугам сүлжээний, худаг, вагончик гэх мэт) хамааруулна. Албан ажлын, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл болон хөдөө аж ахуйн гэх мэт зориулалтаар баригдсан боловч хүмүүс оршин сууж, амьдрахаар засварлаж, тохижуулсан барилга байшин, хүн амьдран суухад ашиглагдаж байгаа бүх төрлийн орон байр, оромжийг *сууцанд* оруулна.

Гэр нь бүх төрлийн монгол гэр болон цаатны суудаг урцыг хамруулна.

Орон сууцны байшин гэдэг нь бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь дэд бүтцийн бүх төрлийн суурь хагамжаар тоноглогдсон, дараах нөхцлийг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд:

- Цахилгаан, дулааны шугам, сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй
- Сууцны дотор бие засах газартай
- Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй
- Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай байна

Сууцны тусдаа байшин гэдэг нь ихэвчлэн гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.

- Халаалтын систем болон усан хангамж
- Дотроо бие засах газар
- Онгоц
- Шүршүүр
- Гал тогоо

Бие даасан тохилог сууц (хаус) гэдэг нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй байна. Үүнд:

- Дотроо боловсон бие засах газартай (ус татдаг)
- Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй
- Орц, туслах өрөө тасалгаа, дээврийн хөндий, зоройн давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалттай сууцыг үүнд хамааруулна
- Сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүүгээтэй мөн мансардтай болон мансардгүй байж болно

Нийтийн байр гэдэг нь иргэд бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ амьдран суудаг, олон өрөөтэй сууцыг нийтийн байранд хамааруулна. Нийтийн байр нь ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. *Нийтийн байр* гэдэгт бүх шатны сургуулийн оюутан, сурагчдын дотуур байр, түүнтэй адилтгах бусад нийтийн байр зэрэг оюутан, сурагчдын дотуур байр болон аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид хамтран буюу ганц нэгээрээ суухад зориулагдсан нийтийн байр зэрэг байгууллагын ажиллагчдын байр орно.

Нийтийн зориулалтын бусад байр гэдэг нь нийтийн зориулалтын бусад байр гэдэгт амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, шорон, цэргийн хуаран зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байрыг хамааруулна.

- Амралтын газар: хот, суурин газар болон түүнээс гадагш байрласан, амралт, чөлөөт цаг өнгөрөөх хэрэгслээр тоноглогдсон үзвэр, үйлчилгээ үзүүдэг цогцолборыг
- Рашаан сувиллын газар: эмчилгээний техник хэрэгслээр тоноглогдсон газрыг ойлгоно
- Зочид буудал: хот, бусад суурин газарт байрласан зочид, үйлчлүүлэгчдийг хүлээн авч байр, хоолны болон бусад үйлчилгээ үзүүлдэг газрыг
- Түр хоноглох байр: авто буудал, дэн буудлын болон түүнтэй төстэй бусад үйл ажиллагаа явуулдаг газрыг ойлгоно

Зориулалтын бус сууц гэдэг нь анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй, хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж, тохижуулсан, гэхдээ тоолох үед хүн амьдарч байгаа сууц багтана. Энэ нь сургууль, үйлдвэр, албан газар, байгууллагын хэсэг буюу өрөө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага байрлахад зориулагдсан) өрх айл, хүн ам амьдарч байвал зориулалтын бус сууц гэж үзнэ. Жишээлбэл, вагончик амбаар, пин, агуулах, дэлгүүр, мухлаг зэрэгт өрх айл, хүн амьдарч байгаа бол зориулалтын бус сууц гэж үзнэ.

4. Хэрвээ сууц нь гэр биш бол, сууцны ханын үндсэн материалын төрөл юу вэ?
- А. Гэр
 - В. Мод, чулуу, бусад
 - С. Тоосго юм уу бетон

Хэрэв сууц нь гэр бол, энэхүү асуултыг асуугдагчаас асуух хэрэггүй. А. Гэр гэсэн хариултыг дугуйлж дараагийн асуулт руу шилжинэ үү.

Судлаачийн гарын авлагын дагуу сууцны ханын үндсэн материалын төрлийг бүртгэнэ. тухайн байшингийн ханыг барьсан үндсэн материалыг бичнэ. Өөрөөр хэлбэл хүнд даацын бус ханын гадуур өнгөлсөн цаас, өнгөт хавтан, шавар зэргийг тооцохгүй.

Үндсэн материал гэдэг нь ханын дийлэнх эзлэгдэхүүнийг тооцдог материалыг хэлнэ.

Хэрэв асуугдагч нь сууцны хана нь тэнцүү эзлэгдэхүүнтэй хоёр болон түүнээс дээш төрлийн материалаар хийгдсэн гэж мэдээллэвэл асуултын хамгийн өндөр оноог авах материалын төрөлд харгалзах хариултыг дугуйлна.

Бусад бүх асуултуудын адил энэхүү асуултыг асуугдагчаас өөрөөс нь асууна. Тухайлбал, та дан ганц өөрийн үнэлэмжээр ханын материалыг тодорхойлж дугуйлж болохгүй.

Судлаачийн гарын авлагын дагуу, *бетон хана* гэдэгт үйлдвэрийн бетон хана (угсармал орон сууцнууд) болон өрх өөрсдөө цемент, элс, хайргаар зуурч босгосон ханыг оруулна.

5. Хэрэв сууц нь гэр бол, гэр нь хэдэн ханатай вэ?
- A. Гэр биш
 - B. 3 эсвэл 4
 - C. 5
 - D. 6 эсвэл түүнээс дээш

Хэрэв сууц нь гэр биш бол энэхүү асуултыг асуугдагчаас асуух хэрэггүй харин А. Гэр биш гэсэн хариултыг дугуйлаад дараагийн асуулт руу шилжинэ үү.

Судалаачийн гарын авлагад үүний талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулаагүй болно.

6. Танай өрх одоогийн байдлаар хэдэн толгой үхэртэй вэ?
- A. 0–4 хүртэл
 - B. 5–9 хүртэл
 - C. 10–29 хүртэл
 - D. 30 болон түүнээс дээш

Судлаачийн гарын авлагад энэхүү асуултын талаар дэлгэрэнгүй тайлбар оруулаагүй болно.

УБСЕГ-ны Судлаачийн гарын авлагын дагуу, асуугдагч өрхийн эзэмшлийн нийт толгой үхэрийн тоог өрхийн гишүүн бус хэн нэгэн маллаж байсан ч бүртгэх нь зүйтэй. Харин эсрэгээр асуугдагч өрх нь өөрийн өмчлөлийн бус үхэрийг маллаж байвал тухайн толгой үхэрийг энэхүү асуултын зорилгод нийцэхгүй гэж үзэн бүртгэхгүй.

7. Танай өрхөд ажиллаж байгаа угаалгын машин бий юу?
- А. Үгүй
 - В. Тийм

УБСЕГ-ны Судлаачийн гарын авлагын дагуу угаалгын машиныг бүрэн автомат эсвэл гар ажиллагаат эсэхээс үл хамааран зөвхөн ажиллаж байгаа угаалгын машиныг бүртгэнэ. Дан ганц бизнесийн зориулалтаар хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэхгүй, харин өрхийн болон бизнесийн зориулалтын аль альнаар нь хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэнэ.

8. Танай өрхөд ажиллаж байгаа зуух/пийшин, цахилгаан эсвэл хийн зуух эсвэл шарах шүүгээ бий юу?
- A. Үгүй
 - B. Зуух/пийшин бий, бусад нь байхгүй
 - C. Цахилгаан эсвэл хийн зуух бий, шарах шүүгээ байхгүй (зуух/пийшин байгаа эсэх нь хамаагүй)
 - D. Шарах шүүгээ бий (бусад нь байгаа эсэх нь хамаагүй)

УБСЕГ-ны Судлаачийн гарын авлагын дагуу зөвхөн ажиллаж байгаа зуух/пийшин, цахилгаан эсвэл хийн зуух болон шарах шүүгээг бүртгэнэ. Дан ганц бизнесийн зориулалтаар хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэхгүй, харин өрхийн болон бизнесийн зориулалтын аль альнаар нь хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэнэ.

Энэ асуултыг 3 хэсэгчилж асууна.

- Танай өрхөд ажиллаж байгаа зуух/пийшин бий юу?
- Танай өрхөд ажиллаж байгаа цахилгаан эсвэл хийн зуух бий юу?
- Танай өрхөд ажиллаж байгаа шарах шүүгээ бий юу?

Дараах 3 дэд асуултанд таарах 3 хариултын нийлбэрээр хариуг дугуйлна уу.

Зуух/пийшин бий юу?	Цахилгаан эсвэл хийн зуух бий юу?	Шарах шүүгээ бий юу?	Хариу
Үгүй	Үгүй	Үгүй	A
Тийм	Үгүй	Үгүй	B
Үгүй	Тийм	Үгүй	C
Тийм	Тийм	Үгүй	C
Үгүй	Үгүй	Тийм	D
Тийм	Үгүй	Тийм	D
Үгүй	Тийм	Тийм	D
Тийм	Тийм	Тийм	D

9. Танай өрхөд ажиллаж байгаа битүү чанагч/будaa агшаагч бий юу?
- А. Үгүй
 - В. Тийм

УБСЕГ-ны судлачийн гарын авлагын дагуу зөвхөн ажиллаж байгаа битүү чанагч/будaa агшаагчийг бүртгэнэ. Дан ганц бизнесийн зориулалтаар хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэхгүй, харин өрхийн болон бизнесийн зориулалтын аль альнаар нь хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэнэ.

Энэхүү асуултын зорилгын дагуу, битүү чанагч гэдэг нь өөртөө цахилгааны үүсгүүртэй эсвэл зуух дээр байрлаж хоол хийхэд зориулагдсан битүүмжилсэн таглаа бүхий цахилгаан хэрэгслийг хэлнэ. Мөн үүнд ус буцалгагч, цахилгаан тогоо болон битүүмжилсэн таглаагүй бол өөр ямар ч төрлийн тогоог оруулахгүй болно.

10. Танай өрхөд ажиллаж байгаа цахилгаан индүү бий юу?

А. Үгүй

В. Тийм

УБСЕГ-ны Судлаачийн гарын авлагын дагуу зөвхөн ажиллаж байгаа цахилгаан индүүг бүртгэнэ. Дан ганц бизнесийн зориулалтаар хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэхгүй, харин өрхийн болон бизнесийн зориулалтын аль альнаар нь хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэнэ.

11. Танай өрхөд ажиллаж байгаа тоос сорогч бий юу?

А. Үгүй

В. Тийм

УБСЕГ-ны Судлаачийн гарын авлагын дагуу зөвхөн ажиллаж байгаа тоос сорогчийг бүртгэнэ. Дан ганц бизнесийн зориулалтаар хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэхгүй, харин өрхийн болон бизнесийн зориулалтын аль альнаар нь хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэнэ.

12. Танай өрхөд ажиллаж байгаа мотоцикл эсвэл автомашины (суудлын машин, ачааны болон хүнд даацын машин, автобус) аль нэг нь бий юу?

- А. Байхгүй
- В. Зөвхөн мотоцикл бий
- С. Автомашин бий /мотоцикл байгаа эсэх нь хамаагүй /

УБСЕГ-ны Судлаачийн гарын авлагын дагуу зөвхөн ажиллаж байгаа мотоцикл, суудлын автомашин, ачааны болон хүнд даацын машин эсвэл автобусын аль нэг байвал бүртгэнэ. Дан ганц бизнесийн зориулалтаар хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэхгүй, харин өрхийн болон бизнесийн зориулалтын аль альнаар нь хэрэглэгдэж байгаа хөрөнгийг бүртгэнэ.

Энэхүү асуултын зорилгын дагуу, “автомашин” гэдэг нь 4 дугуйтай өөрөө явагч тээврийн хэрэгслийг хэлнэ.

Энэхүү асуултыг 2 хэсэгчилж асууна:

- Танай өрхөд ажиллаж байгаа мотоцикл бий юу?
- Танай өрхөд ажиллаж байгаа суудлын автомашин, ачааны машин болон хүнд даацын машин эсвэл автобус бий юу?

Дараах 2 дэд асуултанд таарах 2 хариултын нийлбэрээр хариуг дугуйлна уу.

Мотоцикл бий юу?	Автомашин бий юу?	Хариу
Үгүй	Үгүй	А
Тийм	Үгүй	В
Үгүй	Тийм	С
Тийм	Тийм	С

Хүснэгт 1: Монголын ядуурлын шугам, ядуурлын түвшин, түүврийн хэмжээ ба бүтэц болон баталгаажуулалт, 2014 оны хүн ам, өрхөөр

		Ядуурлын шугамууд (Өдөрт нэг хүнд ноогдох ₮) ба Ядуурлын түвшин (%)																	
Шугам эсвэл хувь	Өнээс-ны Өрхүүд	ӨНЭЭС- ны өрхүүд	Үндэсний Ядуурлын Шугамууд			Хамгийн ядуу хагас <100% үндэсний хэмжээнд	2005 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам				2011 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам				Хувьчилсан ядуурлын шугамууд				
			100%	150%	200%		\$1.25	\$2.00	\$2.50	\$5.00	\$1.90	\$3.10	\$3.80	\$4.00	20 th	40 th	50 th	60 th	80 th
<u>Монгол улс</u>																			
Шугам	Өрхүүд		4,821	7,232	9,643	3,769	1,666	2,666	3,333	6,666	1,582	2,582	3,165	3,331	4,692	6,397	7,318	8,412	11,636
хувь	Өнээс	16,174	16.2	40.9	61.5	7.5	0.2	2.0	4.9	35.0	0.1	1.7	4.0	4.9	14.9	32.1	41.7	51.6	73.4
хувь	Өрхүүд		21.6	49.3	69.3	10.8	0.3	3.2	7.2	43.0	0.2	2.7	5.9	7.2	20.0	40.0	50.0	60.0	80.0
<u>Бүтэц болон тохируулга (Үзүүдэлт болон оноог сонгон тохирох ядуурлын магадлалын дүнтэй холбох)</u>																			
хувь	Өнээс	7,992	16.2	41.0	61.5	7.5	0.2	2.1	4.9	35.0	0.1	1.7	4.0	4.9	14.9	32.4	41.7	51.7	73.2
<u>Үнэлгээ (Хэмжигдэхүүний нарийвчлал)</u>																			
хувь	Өнээс	8,182	16.2	40.9	61.4	7.5	0.2	2.0	4.9	35.0	0.1	1.7	3.9	4.9	14.9	31.9	41.7	51.5	73.6

Эх сурвалж (2014 оны ӨНЭЭС)

Ядуурлын шугамууд нь 2014 оны нийт Монгол Улсын дундаж үнэ өртгөөр тооцсон нэг өдөрт нэг хүнд ноогдох төгрөгийн нэгж байна.

Хүснэгт 2. (Нийт Монгол улсаар болон аймгаар) 2014 оны хүн ам, өрхийн ядуурлын шугам болон ядуурлын түвшин

		Ядуурлын шугамууд (Өдөрт нэг хүнд ноогдох ₮) ба Ядуурлын түвшин (%)																	
Aimags	Шугам/түвшин	ӨНЭЭС-ны өрхүүд	Үндэсний Ядуурлын Шугамууд			Хамгийн ядуу хагас <100% үндэсний хэмжээнд	2005 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам				2011 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам				Хувьчилсан ядуурлын шугамууд				
			100%	150%	200%		\$1.25	\$2.00	\$2.50	\$5.00	\$1.90	\$3.10	\$3.80	\$4.00	20 th	40 th	50 th	60 th	80 th
Монгол улс	Шугам	16,174	4,821	7,232	9,643	3,769	1,666	2,666	3,333	6,666	1,582	2,582	3,165	3,331	4,692	6,397	7,318	8,412	11,636
	Хүмүүсийн түвшин		16.2	40.9	61.5	7.5	0.2	2.0	4.9	35.0	0.1	1.7	4.0	4.9	14.9	32.1	41.7	51.6	73.4
	Өрхийн түвшин		21.6	49.3	69.3	10.8	0.3	3.2	7.2	43.0	0.2	2.7	5.9	7.2	20.0	40.0	50.0	60.0	80.0
Улаанбаатар хот	Шугам	3,581	4,968	7,452	9,935	3,883	1,717	2,747	3,434	6,868	1,630	2,660	3,261	3,432	4,834	6,591	7,540	8,667	11,989
	Хүмүүсийн түвшин		12.1	32.1	51.5	6.1	0.2	2.0	4.4	27.3	0.2	1.6	3.7	4.4	11.4	24.8	32.6	41.2	64.1
	Өрхийн түвшин		16.4	40.1	59.9	9.2	0.2	3.2	6.6	34.7	0.2	2.6	5.8	6.6	15.7	32.0	40.6	49.9	72.1
Дорнод	Шугам	624	4,693	7,039	9,385	3,668	1,622	2,595	3,244	6,488	1,540	2,513	3,080	3,242	4,567	6,226	7,123	8,188	11,325
	Хүмүүсийн түвшин		20.7	53.8	74.4	9.5	0.0	1.0	3.9	45.6	0.0	0.9	3.2	3.9	18.7	43.1	54.8	67.4	83.0
	Өрхийн түвшин		29.8	65.4	83.2	14.9	0.0	1.9	6.4	57.3	0.0	1.6	5.4	6.4	27.2	54.9	65.9	77.2	89.9
Сүхбаатар	Шугам	624	4,743	7,115	9,486	3,707	1,639	2,623	3,279	6,558	1,557	2,540	3,113	3,277	4,616	6,293	7,199	8,275	11,447
	Хүмүүсийн түвшин		24.1	53.8	72.7	14.0	0.1	5.3	9.9	46.4	0.1	4.9	8.3	9.9	22.9	43.6	54.6	63.0	82.1
	Өрхийн түвшин		30.7	62.2	79.9	18.8	0.4	7.9	14.0	54.6	0.4	7.5	11.9	14.0	29.0	52.2	62.7	70.3	87.3
Хэнтий	Шугам	624	4,765	7,148	9,531	3,725	1,647	2,635	3,294	6,589	1,564	2,552	3,128	3,293	4,638	6,323	7,233	8,314	11,501
	Хүмүүсийн түвшин		26.1	48.3	67.2	15.7	0.2	4.5	9.8	42.8	0.2	4.3	8.6	9.8	23.9	40.1	49.0	59.1	76.8
	Өрхийн түвшин		33.7	56.8	74.1	21.8	0.4	7.5	14.2	51.6	0.4	7.1	12.7	14.2	31.4	49.2	57.2	66.7	82.7
Төв	Шугам	624	4,691	7,036	9,381	3,666	1,621	2,594	3,243	6,485	1,539	2,512	3,079	3,241	4,565	6,223	7,119	8,184	11,320
	Хүмүүсийн түвшин		12.4	34.5	54.6	4.7	0.0	1.7	3.4	28.5	0.0	1.3	2.9	3.4	10.9	26.4	34.6	43.7	66.5
	Өрхийн түвшин		17.1	42.1	61.7	6.8	0.0	2.9	4.9	35.4	0.0	2.5	4.3	4.9	15.4	33.2	42.2	51.5	72.3
Говьсүмбэр	Шугам	216	4,750	7,125	9,500	3,713	1,642	2,627	3,284	6,567	1,559	2,544	3,118	3,282	4,623	6,302	7,210	8,288	11,464
	Хүмүүсийн түвшин		40.0	70.4	83.3	23.9	0.6	4.5	12.8	62.9	0.6	4.0	8.9	12.8	35.2	61.1	71.3	78.9	89.5
	Өрхийн түвшин		47.9	76.8	88.2	30.6	1.0	6.8	16.0	70.2	1.0	6.1	11.8	16.0	43.3	68.4	77.6	84.4	93.1
Сэлэнгэ	Шугам	624	4,700	7,050	9,400	3,674	1,625	2,599	3,249	6,498	1,543	2,517	3,085	3,248	4,574	6,236	7,134	8,200	11,343
	Хүмүүсийн түвшин		26.0	52.4	70.8	14.3	1.1	4.7	10.9	46.9	0.7	4.2	8.1	10.9	24.2	45.2	52.5	62.9	81.8
	Өрхийн түвшин		35.2	64.2	80.0	21.0	2.5	8.0	17.0	58.1	1.6	7.3	13.0	17.0	32.8	56.6	64.3	74.1	88.4
Дорноговь	Шугам	622	4,893	7,339	9,785	3,824	1,691	2,706	3,382	6,764	1,606	2,620	3,212	3,381	4,761	6,491	7,426	8,536	11,808
	Хүмүүсийн түвшин		14.1	39.3	61.1	5.5	0.0	1.1	4.0	33.4	0.0	1.0	3.5	4.0	11.8	30.2	41.0	53.0	75.3
	Өрхийн түвшин		17.8	46.3	69.2	7.5	0.0	1.7	5.6	40.1	0.0	1.4	5.0	5.6	15.0	36.5	48.0	61.3	81.8
Дархан-Уул	Шугам	549	4,823	7,235	9,647	3,770	1,667	2,667	3,334	6,669	1,583	2,583	3,166	3,333	4,694	6,399	7,321	8,415	11,641
	Хүмүүсийн түвшин		15.6	37.9	61.0	7.8	0.0	2.5	5.2	33.2	0.0	2.2	4.3	5.2	14.4	31.4	38.9	50.7	72.8
	Өрхийн түвшин		21.4	47.9	69.9	11.1	0.0	4.2	7.8	42.3	0.0	3.8	6.5	7.8	20.1	40.6	49.0	60.7	81.2
Өмнөговь	Шугам	622	4,908	7,362	9,817	3,837	1,697	2,714	3,393	6,786	1,611	2,628	3,222	3,391	4,777	6,512	7,450	8,564	11,846
	Хүмүүсийн түвшин		6.9	27.2	47.4	2.1	0.0	0.1	0.8	21.5	0.0	0.0	0.8	0.8	5.6	18.8	27.9	38.3	61.8
	Өрхийн түвшин		10.1	35.1	56.8	3.0	0.0	0.0	1.1	28.3	0.0	0.0	1.1	1.1	8.1	25.3	36.0	47.8	71.2
Дундговь	Шугам	624	4,624	6,937	9,249	3,615	1,598	2,557	3,197	6,394	1,518	2,476	3,035	3,195	4,500	6,136	7,019	8,068	11,161
	Хүмүүсийн түвшин		16.6	43.6	67.8	7.6	0.0	1.5	4.4	37.4	0.0	1.0	3.6	4.4	15.9	34.2	44.8	54.8	83.1
	Өрхийн түвшин		20.9	51.4	74.8	10.7	0.0	2.2	6.2	44.5	0.0	1.4	5.3	6.2	20.4	40.7	52.9	63.6	88.6
Орхон	Шугам	600	4,876	7,313	9,751	3,811	1,685	2,696	3,370	6,741	1,600	2,611	3,200	3,369	4,745	6,469	7,400	8,507	11,767
	Хүмүүсийн түвшин		10.2	26.2	45.5	5.2	0.5	1.7	3.3	21.3	0.3	1.3	3.0	3.3	9.6	19.0	26.8	36.2	56.9
	Өрхийн түвшин		14.8	33.3	53.5	8.4	0.6	2.8	5.8	28.0	0.5	2.2	5.2	5.8	14.0	25.6	33.8	44.0	65.0
Өвөрхангай	Шугам	624	4,592	6,887	9,183	3,589	1,587	2,539	3,174	6,348	1,507	2,459	3,014	3,173	4,468	6,092	6,969	8,011	11,082
	Хүмүүсийн түвшин		25.0	58.4	78.2	10.2	0.0	2.4	6.4	52.7	0.0	2.3	5.0	6.4	22.6	48.0	60.0	69.7	87.8
	Өрхийн түвшин		34.2	67.3	83.9	14.4	0.0	4.3	9.5	62.3	0.0	4.2	7.8	9.5	30.8	57.9	68.3	77.1	91.5
Булган	Шугам	624	4,677	7,015	9,353	3,655	1,616	2,586	3,233	6,466	1,535	2,504	3,070	3,231	4,551	6,205	7,098	8,159	11,286
	Хүмүүсийн түвшин		17.9	50.8	72.5	8.2	0.0	2.1	4.4	44.9	0.0	1.5	3.8	4.4	16.7	40.4	52.4	64.1	84.8
	Өрхийн түвшин		26.2	63.1	81.3	12.8	0.0	2.8	6.8	56.5	0.0	1.9	5.8	6.8	24.8	51.9	64.5	74.6	90.4
Баянхонгор	Шугам	624	4,655	6,983	9,311	3,639	1,609	2,575	3,218	6,436	1,528	2,493	3,056	3,217	4,530	6,177	7,066	8,122	11,235
	Хүмүүсийн түвшин		15.8	44.3	70.6	4.2	0.0	0.9	2.5	37.7	0.0	0.9	2.0	2.5	13.6	34.3	45.0	58.8	82.8
	Өрхийн түвшин		21.5	54.2	79.2	5.6	0.0	1.0	3.2	47.8	0.0	1.0	2.7	3.2	18.5	44.1	54.9	68.4	88.4
Архангай	Шугам	624	4,640	6,959	9,279	3,627	1,604	2,566	3,207	6,415	1,523	2,484	3,045	3,206	4,515	6,156	7,042	8,095	11,197
	Хүмүүсийн түвшин		15.2	47.3	76.8	6.8	0.0	0.9	4.1	37.1	0.0	0.9	2.8	4.1	13.9	31.9	48.5	64.4	90.3
	Өрхийн түвшин		20.3	54.3	83.1	9.3	0.0	1.0	5.6	44.4	0.0	1.0	3.8	5.6	18.7	39.4	55.4	71.6	93.3
Хөвсгөл	Шугам	624	4,602	6,904	9,205	3,597	1,591	2,545	3,182	6,363	1,511	2,465	3,021	3,180	4,479	6,106	6,986	8,030	11,107
	Хүмүүсийн түвшин		24.4	59.3	79.0	11.0	0.3	1.3	7.2	51.8	0.3	0.9	4.4	7.2	22.7	48.2	60.4	72.1	88.9
	Өрхийн түвшин		31.0	68.8	86.6	15.4	0.3	2.0	10.7	61.4	0.3	1.3	6.8	10.7	29.2	57.1	69.9	80.6	94.1
Завхан	Шугам	624	4,848	7,271	9,695	3,789	1,676	2,681	3,351	6,702	1,591	2,596	3,182	3,349	4,718	6,432	7,358	8,458	11,699
	Хүмүүсийн түвшин		11.7	39.2	60.8	1.5	0.0	0.4	1.0	31.0	0.0	0.3	0.8	1.0	10.2	27.2	39.8	47.2	78.9
	Өрхийн түвшин		15.5	45.4	66.8	2.2	0.0	0.7	1.6	36.9	0.0	0.5	1.3	1.6	13.3	32.4	46.1	53.4	84.3
Говь-Алтай	Шугам	624	4,687	7,031	9,374	3,664	1,620	2,592	3,240	6,480	1,538	2,510	3,077	3,239	4,561	6,219	7,114	8,178	11,312
	Хүмүүсийн түвшин		30.9	66.9	87.9	14.5	0.7	3.8	8.2	59.6	0.6	3.3	7.1	8.2	28.0	55.3	68.0	78.7	94.3
	Өрхийн түвшин																		

Хүснэгт 2. (Нийт Монгол, Баруун, Уулархаг, Төв, Зүүн ба Улаанбаатар бүс) 2014 оны хүм ам, өрхийн ядуурлын шугам ба ядуурлын түвшин

		Ядуурлын шугамууд (Өдөрт нэг хүнд ноогдох ₮) ба Ядуурлын түвшин (%)																	
5 түвшиний бүс	Шугам/түвшин	ӨНЭЗ С-ны өрхүүд	Үндэсний Ядуурлын Шугамууд			Хамгийн ядуу хагас <100% үндэсний хэмжээнд	2005 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам				2011 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам				Хувьчилсан ядуурлын шугамууд				
			100%	150%	200%		\$1.25	\$2.00	\$2.50	\$5.00	\$1.90	\$3.10	\$3.80	\$4.00	20 th	40 th	50 th	60 th	80 th
Монгол улс	Шугам		4,821	7,232	9,643	3,769	1,666	2,666	3,333	6,666	1,582	2,582	3,165	3,331	4,692	6,397	7,318	8,412	11,636
	Хүмүүсийн түвшин		16.2	40.9	61.5	7.5	0.2	2.0	4.9	35.0	0.1	1.7	4.0	4.9	14.9	32.1	41.7	51.6	73.4
	Өрхийн түвшин	16,174	21.6	49.3	69.3	10.8	0.3	3.2	7.2	43.0	0.2	2.7	5.9	7.2	20.0	40.0	50.0	60.0	80.0
Баруун	Шугам		4,704	7,055	9,407	3,677	1,626	2,601	3,252	6,503	1,544	2,519	3,087	3,250	4,577	6,241	7,139	8,207	11,352
	Хүмүүсийн түвшин		20.7	51.8	73.3	7.9	0.1	1.7	4.4	44.0	0.1	1.5	3.3	4.4	18.8	40.4	52.8	62.6	84.7
	Өрхийн түвшин	3,120	26.0	58.4	78.9	10.4	0.2	2.5	6.1	50.9	0.2	2.2	4.4	6.1	23.5	47.4	59.6	69.0	88.5
Уулархаг нутаг	Шугам		4,664	6,997	9,329	3,646	1,612	2,580	3,224	6,449	1,531	2,498	3,062	3,223	4,539	6,189	7,080	8,138	11,257
	Хүмүүсийн түвшин		18.7	48.8	71.4	7.9	0.1	1.5	4.9	41.9	0.1	1.3	3.6	4.9	17.1	38.0	50.0	62.0	82.7
	Өрхийн түвшин	3,720	25.3	57.7	78.8	11.2	0.2	2.3	7.3	50.9	0.1	1.9	5.5	7.3	23.2	46.9	58.7	70.3	87.7
Төвийн бүс	Шугам		4,768	7,152	9,535	3,727	1,648	2,637	3,296	6,592	1,565	2,553	3,130	3,294	4,640	6,326	7,236	8,318	11,506
	Хүмүүсийн түвшин		16.7	40.6	61.4	8.0	0.2	2.3	5.5	35.0	0.2	1.9	4.3	5.5	15.1	32.7	41.4	51.9	73.8
	Өрхийн түвшин	3,881	22.2	49.5	69.6	11.3	0.5	3.7	8.0	43.2	0.4	3.3	6.5	8.0	20.3	40.8	50.3	61.1	80.8
Зүүн бүс	Шугам		4,733	7,099	9,465	3,699	1,636	2,617	3,272	6,543	1,553	2,534	3,106	3,270	4,606	6,279	7,183	8,257	11,422
	Хүмүүсийн түвшин		23.6	51.9	71.4	12.9	0.1	3.4	7.6	44.8	0.1	3.2	6.5	7.6	21.7	42.2	52.7	63.3	80.5
	Өрхийн түвшин	1,872	31.4	61.4	79.0	18.4	0.3	5.6	11.3	54.5	0.3	5.2	9.8	11.3	29.2	52.1	61.9	71.5	86.7
Улаанбаатар хот	Шугам		4,968	7,452	9,935	3,883	1,717	2,747	3,434	6,868	1,630	2,660	3,261	3,432	4,834	6,591	7,540	8,667	11,989
	Хүмүүсийн түвшин		12.1	32.1	51.5	6.1	0.2	2.0	4.4	27.3	0.2	1.6	3.7	4.4	11.4	24.8	32.6	41.2	64.1
	Өрхийн түвшин	3,581	16.4	40.1	59.9	9.2	0.2	3.2	6.6	34.7	0.2	2.6	5.8	6.6	15.7	32.0	40.6	49.9	72.1

Эх сурвалж: Хүснэгт 1-ийг харна уу

Хүснэгт 2. (Нийт Монгол, Улаанбаатар, Аймгийн төвүүд, Сумын төвүүд болон Хөдөө) 2014 оны хүн ам, өрхийн ядуурлын шугам болон ядуурлын түвшин

		Ядуурлын шугамууд (Өдөрт нэг хүнд ноогдох ₮) ба Ядуурлын түвшин (%)																	
4 түвшиний бүс	Шугам/түвшин	ӨНЭЭС-ны өрхүүд	National poverty lines			Хамгийн ядуу хагас <100% үндэсний хэмжээнд	2005 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам				2011 оны ХАЧП-ээр тооцсон ядуурлын шугам				Хувьчилсан ядуурлын шугамууд				
			100%	150%	200%		\$1.25	\$2.00	\$2.50	\$5.00	\$1.90	\$3.10	\$3.80	\$4.00	20 th	40 th	50 th	60 th	80 th
Монгол улс	Шугам		4,821	7,232	9,643	3,769	1,666	2,666	3,333	6,666	1,582	2,582	3,165	3,331	4,692	6,397	7,318	8,412	11,636
	Хүмүүсийн түвшин		16.2	41.0	61.5	7.5	0.2	2.0	4.9	35.0	0.1	1.7	4.0	4.9	14.9	32.1	41.7	51.6	73.4
	Өрхийн түвшин	16,174	21.6	49.3	69.3	10.8	0.3	3.2	7.2	43.0	0.2	2.7	5.9	7.2	20.0	40.0	50.0	60.0	80.0
Улаанбаатар хот	Шугам		4,968	7,452	9,935	3,883	1,717	2,747	3,434	6,868	1,630	2,660	3,261	3,432	4,834	6,591	7,540	8,667	11,989
	Хүмүүсийн түвшин		12.1	32.1	51.5	6.1	0.2	2.0	4.4	27.3	0.2	1.6	3.7	4.4	11.4	24.8	32.6	41.2	64.1
	Өрхийн түвшин	3,581	16.4	40.1	59.9	9.2	0.3	3.2	6.6	34.7	0.2	2.6	5.8	6.6	15.7	32.0	40.6	49.9	72.1
Аймгийн төв	Шугам		4,832	7,247	9,663	3,777	1,670	2,672	3,340	6,680	1,586	2,587	3,171	3,338	4,702	6,410	7,333	8,430	11,660
	Хүмүүсийн түвшин		18.1	43.2	64.4	8.8	0.2	2.3	5.1	36.8	0.2	2.0	4.3	5.1	16.6	34.1	44.0	54.9	76.0
	Өрхийн түвшин	5,400	23.8	50.9	71.5	12.3	0.4	3.6	7.3	44.3	0.3	3.1	6.3	7.3	22.1	41.7	51.7	62.5	82.0
Сумын төв	Шугам		4,674	7,011	9,348	3,653	1,615	2,585	3,231	6,462	1,534	2,503	3,068	3,229	4,548	6,201	7,094	8,154	11,280
	Хүмүүсийн түвшин		18.3	46.5	68.3	8.1	0.3	2.0	5.2	39.7	0.2	1.8	3.6	5.2	16.8	36.6	47.7	57.9	80.3
	Өрхийн түвшин	3,794	24.7	55.7	75.8	11.6	0.5	3.3	7.7	48.6	0.4	3.0	5.6	7.7	22.8	45.3	56.7	66.7	85.9
Хөдөө	Шугам		4,616	6,924	9,232	3,608	1,595	2,553	3,191	6,382	1,515	2,472	3,030	3,189	4,492	6,124	7,006	8,053	11,140
	Хүмүүсийн түвшин		21.5	53.4	74.6	8.8	0.0	1.8	5.8	46.3	0.0	1.5	4.4	5.8	19.2	42.3	54.2	65.7	85.1
	Өрхийн түвшин	3,399	27.9	62.2	82.0	12.0	0.0	2.6	8.0	55.2	0.0	2.2	6.1	8.0	25.0	51.4	63.1	73.9	90.2

Эх сурвалж: Хүснэгт 1-ийг харна уу

Хүснэгт 2. (Нийт Монгол, Улаанбаатар, Аймгийн төвүүд, Сумын төвүүд болон Хөдөө 2014 оны хүн ам, өрхийн ядуурлын шугам болон ядуурлын түвшин)

		Ядуурлын шугамууд (Өдөрт нэг хүнд ноогдох ₮) ба Ядуурлын түвшин (%)																	
